

**DeFacto**

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД

# АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2019

*Улаанбаатар хот*

Canada 



The Asia Foundation

---

*Дефакто Институт Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азийн сангаас хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь (STEPS)” төслийн хүрээнд Улс төрийн намын дотоод ардчиллын индексийг гүйцэтгэв.*

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД

# АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2019

## ЗӨВЛӨХ:

Дамбадаржаагийн Жаргалсайхан  
Эрдэнэбилэгийн Гэрэлт-Од

Дефакто Институтын Гүйцэтгэх захирал  
МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн  
ахлах багш, доктор

## СУДАЛГААНЫ БАГ:

Алтанхуягийн Бат-Оргил  
Бат-Өлзийн Эрдэнэдалай

Дефакто Институтын ахлах судлаач  
“Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын гүйцэтгэх  
захирал, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн  
ахлах багш, доктор

Ганхуягийн Батхишиг

Дефакто Институтын туслах судлаач

## АГУУЛГА

Удиртгал.....	07
Судалгааны хураангуй.....	09
Судалгааны арга зүй.....	10
Намын дотоод ардчилал .....	12
Улс төрийн намын дотоод ардчиллын индекс .....	15
Улс төрийн намын гишүүдийн оролцоо .....	17
Улс төрийн нам доторх өрсөлдөөн.....	18
Улс төрийн намын төлөөлөл.....	20
Улс төрийн намын санхүүжилт, ил тод байдал .....	22
Гадаад орнуудын туршлага.....	24
Дүгнэлт.....	27
Ашигласан эх сурвалж.....	30
Хавсралт .....	31

## ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Зураг 1:	Улс төрийн намын дотоод ардчиллын индекс .....	15
Зураг 2:	Улс төрийн намын дотоод ардчиллын индекс, хэмжигдэхүүн тус бүрээр .....	16
Зураг 3:	2018 ба 2019 оны улс төрийн намын дотоод ардчиллын индексийн харьцуулалт .....	16
Зураг 4:	Улс төрийн намын гишүүдийн оролцоо .....	17
Зураг 5:	Улс төрийн нам доторх өрсөлдөөн .....	18
Зураг 6:	Улс төрийн намын төлөөлөл .....	20
Зураг 7:	Улс төрийн намын санхүүжилт, ил тод байдал .....	22
Хүснэгт 1:	Улс төрийн намын дотоод ардчиллын индекс .....	09
Хүснэгт 2:	Эмэгтэйчүүдийн квот, төрөл .....	26

## ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан Нам
ИЗНН	Иргэний Зориг Ногоон Нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МНН	Монголын Ногоон Нам
СТХ	Сонгуулийн тухай хууль
УДШ	Улсын Дээд Шүүх
УИХ	Улсын Их Хурал
УНТХ	Улс төрийн намын тухай хууль
ҮЗН	Үнэн ба Зөв Нам
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам
ЭОН	Эх Орон Нам

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Азийн санд гүн талархал илэрхийлье. Түүнчлэн бидний судалгаанд цаг заваа харамгүй зориулан үзэл бодлоо хуваалцсан Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам, Иргэний Зориг Ногоон Нам, Хөдөлмөрийн Үндэсний Нам, Монголын Ногоон Нам, Эх Орон Нам, Үнэн ба Зөв Намын төлөөлөл болон гишүүдэд талархаж буйгаа илэрхийлье.

## УДИРТГАЛ

Улс төрийн нам сонгуульд амжилттай оролцож засгийн эрхийг авахын төлөө улс орныг хөгжүүлэх “бодлого, мөрийн хөтөлбөр”-ийг сонгогчдод санал болгодог улс төрийн институт юм. Сонгуульд амжилттай оролцох, сонгуулийн бус үед улс төрийн үйл ажиллагаа явуулж улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, намын бүтцийг тогтвортой ажиллуулах, үүний тулд тухайн улс төрийн намын бүх түвшний гишүүд намын шийдвэрлэх ёстой аливаа асуудалд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, оролцох, бүх төлөөлөх түвшний сонгуулиудад хүйс харгалзахгүйгээр нэр дэвшин өрсөлдөх, нэр дэвшигчид саналаа өгөх, намын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хянах зэргээр намын үйл ажиллагаанд оролцдог хариуцлагатай гишүүдтэй байх нь намын дотоод ардчиллыг тодорхойлно.

1990 онд Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 29 жил өнгөрч байна. Аливаа улсын ардчиллын чанар, бэхжилтийг хангахад улс төрийн нам хамгийн чухал үүрэгтэй. Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан олон намын тогтолцоонд шилжсэн цагаас хойш улс төрийн намуудын тоо тогтмол өссөөр эдүгээ Дээд шүүхэд 32 улс төрийн нам бүртгэгджээ. Гэвч өнгөрсөн хугацаанд улс төрийн намуудын төлөвшил, чанарын асуудалд улс төр судлаачид төдийгүй нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандсаар ирлээ. Монголд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгэм болон олон улсын байгууллагуудын тандалт судалгаануудаар Монголын улс төрийн намуудын талаарх иргэд, олон нийтийн сөрөг хандлага давамгайлсаар байна. Тухайлбал, Азийн сан олон улсын байгууллагын түүвэр судалгаагаар олон нийт улс төрийн намуудыг авлигад ихээр өртсөн байгууллагуудын нэг гэж иргэд үзэж байгааг харуулсаар байгаа.

Улс төрийн намууд нь зөвхөн гишүүд, дэмжигчдээсээ гадна олон нийтэд ч үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулах үүрэгтэй. Гэвч ил тод, нээлттэй байх зарчмыг зөвхөн намын гишүүдэд хамаарах дотоод хүрээний асуудал гэж үзэх хандлага намуудын дунд түгээмэл байна. Иймээс Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг бий болгох, гишүүд сонгогчдын саналыг сонсон хүлээн авдаг, үйл ажиллагаа, санхүүжилт ил тод нээлттэй намыг бий болгох зорилготойгоор Намуудын дотоод ардчиллын индексийг 2018 онд анх гаргасан. Цаашид дотоод ардчиллыг улам бэхжүүлэх хүрээнд Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2019” судалгааг хийснээрээ Монголын улс төрийн намуудтай холбоотойгоор гарч буй асуудлуудыг нээлттэй, ил тод байдлаар шийддэг, хариуцлагатай улс төрийн намуудыг бий болгоход хувь нэмэр оруулах зорилготой.

Сүүлийн үед улс төрийн нам судлалын эрдэмтэд төдийгүй олон улсын байгууллагууд ч намын дотоод ардчиллын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч идэвхтэйгээр дэмжих хандлага нэмэгдсээр байна. Цаашлаад намууд бүтэц, зохион байгуулалтдаа дотоод ардчиллын арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх нь ардчиллын үнэт зүйл, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд томоохон хувь нэмэр болох нь гарцаагүй. Ийнхүү Дефакто Институт 2019 оны 4 дүгээр сараас 6 дугаар сарын хооронд 2 дахь удаагаа “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс” судалгааг хийж гүйцэтгэлээ. Өмнөх онтой харьцуулахад судалгаанд хамрагдсан намын тоо 2-оор нэмэгдсэн буюу нийт 8 улс төрийн намыг 2019 оны намын дотоод ардчиллын индексийн судалгаанд хамруулаад байна.

Цаашидуг судалгаа улс төрийн намуудын харьцуулсан судалгаа, тэр дундаа монголын улс төрийн намуудын бүтэц, зохион байгуулалтын талаарх судалгаа, шинжилгээнд шаардлагатай мэдээлэл, эх сурвалж болох, түүнчлэн намын гишүүд, дэмжигчид төдийгүй олон нийтийг намын үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх аливаа үйл ажиллагаанд тус дэм болно гэдэгт итгэж байна.



## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Улс төрийн намын дотоод ардчиллын индексийг “Дефакто институт” болон “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ хамтран Израилийн “Ардчилал” институтийн аргачлалын дагуу 2018 онд анх удаа судалгааны тоон аргыг ашиглан улс төрийн зургаан намыг хамруулан гүйцэтгэсэн. Энэ удаа судалгааны арга зүй, аргачлалыг улам боловсронгуй болгон чанарын судалгааны аргыг ашиглан 2019 оны 5 дугаар сарын байдлаар Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 32 улс төрийн намыг хамруулан судлахаар зорьсон боловч МАН, АН, МАХН, ХҮН, ЭОН, ИЗНН,

МНН, ҮЗН гэсэн 8 улс төрийн нам энэхүү судалгаанд оролцлоо. 2019 оны хувьд улс төрийн намууд өмнөх жилийн үр дүнгээс харьцангуй өндөр оноо авлаа. 2019 оны УИХ-ын 42-р тойргийн нөхөн сонгуультай холбоотойгоор нийт намууд сонгуулийн үйл ажиллагаанд бэлтгэх, нэр дэвшигчдээ тодруулах зорилгоор намын бүхий л түвшинд гишүүдийн оролцоо идэвхжсэн байна. Түүнчлэн 2019 он УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жил гэдгээрээ онцлогтой байв. Энэ утгаараа намууд их хурал, бага хурлаа зохион байгуулах ажлууд эхэлсэн нь индексийн үзүүлэлтүүдэд голчлон нөлөөлөв.

**Хүснэгт 1: Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2019**

№	Улс төрийн нам	Индекс	Ангилал
1	Монголын Ногоон Нам	66	Ардчилсан
2	Монгол Ардын Хувьсгалт Нам	66	Ардчилсан
3	Ардчилсан Нам	65	Ардчилсан
4	Хөдөлмөрийн Үндэсний Нам	63	Ардчилсан
5	Монгол Ардын Нам	55	Хагас ардчилсан
6	Эх Орон Нам	47	Хагас ардчилсан
7	Үнэн ба Зөв Нам	42	Хагас ардчилсан
8	Иргэний Зориг Ногоон Нам	32	Хагас ардчилсан

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Улс төрийн намын дотоод ардчиллын индексийн үнэлгээг улс төрийн намын гишүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага болон экспертийн үнэлгээнд суурилж чанарын судалгааны аргаар боловсрууллаа. Түүнчлэн Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль зэрэг улс төрийн намын орчныг тодорхойлох үндсэн зохицуулалтад үндэслэн Улсын Дээд Шүүхийн нээлттэй мэдээллийн сан болон намуудын үндсэн дүрэм, журам, дотоод ардчилалтай холбоотой намуудад гарсан зарим кейст шинжилгээ хийсэн. Мөн намуудын ил тод байдлын үзүүлэлтийг гаргахад намуудын вэб сайтын мэдээлэлд ажиглалт хийлээ.


Энэхүү индекст Улсын Их Хуралд суудалтай нам, эвслээс гадна 2019 оны 5 дугаар сарын байдлаар Монгол Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй нийт 32 улс төрийн намыг хамруулан тодорхойлохыг зорьсон. Улмаар Улсын Дээд Шүүхийн албан ёсны цахим хуудас дээрх мэдээллийн дагуу улс төрийн намуудтай холбогдсон ч дийлэнх намууд тодорхой болон тодорхой бус шалтгаанаар оролцохоос татгалзсан эсвэл холбогдох мэдээлэл нь буруу байв.

Судалгааны баг улс төрийн намын гишүүдтэй хийх фокус бүлгийн ярилцлагыг дараах байдлаар төлөвлөсөн. Тухайлбал, Монгол

Ардын Нам, Ардчилсан Нам зэрэг олон гишүүнтэй, парламентад тогтмол суудалтай байсаар ирсэн зонхилох хоёр намын гишүүдтэй хийх фокус бүлгийн ярилцлагыг хоёр удаа; Харин парламентад тогтмол суудалгүй, цөөн гишүүд бүхий, шинээр үүсгэн байгуулагдсан зэрэг намуудтай хийх фокус бүлгийн ярилцлагыг тус тус нэг удаа хийхээр зорьсон. Намын гишүүд, төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагуудад нам тус бүрээс дунджаар 6-8 хүн оролцлоо.

Намын вебсайт ба нийгмийн сүлжээний албан ёсны хуудсууд дээрх мэдээллийг 2019 оны 5 дугаар сараас 6 дугаар сарын хооронд хандалт хийн цуглуулсан бөгөөд нийт судалгаанд хамрагдсан 8 улс төрийн намын 5 нь идэвхтэй үйл ажиллагаатай вебсайт эсвэл хуудастай байв. Албан ёсны вебсайтгүй эсвэл үйл ажиллагаа нь идэвхгүй вебсайнтай намуудын нийгмийн сүлжээний хуудсууд дээрх мэдээллийг шүүн ажиллалаа.

Израилийн Ардчилал Институтын үнэлгээнд суурилж урьдчилан боловсруулсан асуулгын дагуу тус бүрдээ үнэлгээ бүхий 5 хэмжигдэхүүнээр тодорхойллоо. Судалгаанд оролцсон нам тус бүрийг 0-100 хүртэлх оноогоор үнэлж намын дотоод ардчиллын түвшинг дараах байдлаар ангилав.



АРДЧИЛАЛГҮЙ  
0-30 ОНОО

ХАГАС АРДЧИЛСАН  
31-60 ОНОО

АРДЧИЛСАН  
61-100 ОНОО

## НАМЫН ДОТООД АРДЧИЛАЛ

Намын дотоод ардчилал буюу “internal democracy within political party”, нам доторх ардчилал буюу “intra-party democracy” хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л төвшинд гишүүд, дэмжигчдийг оролцуулах өргөн хүрээний үе шатуудаар тодорхойлогдоно.

Эдүгээ улс төрийн нам судлаачид намын дотоод ардчиллыг хэмжих тэр дундаа индексжүүлэх хэд хэдэн оролдлогыг хийгээд байна. Үүнд харьцуулсан улс төр, улс төрийн нам судлалын голлох эрдэмтэд болох Томас Погунке, Сузань Скарроу, Пол Вебб нараар ахлуулсан Улстөрийн намуудын өгөгдлийн сангийн төсөл, Гидеон Рахат, Асаф Шапира нарын Израйлын Ардчилал Институтын Улс төрийн шинэтгэл төслийн хүрээнд боловсруулсан индексүүд багтана. Улс төрийн намуудын өгөгдлийн сангаас боловсруулсан индекс нь их хуралд үндэслэсэн (assembly-based) ба бүх гишүүдийн санал хураалтад үндэслэсэн (plebiscitary) намын дотоод ардчиллын индекс гэсэн 2 төрөл байна.

Монголын хуулийн зохицуулалтаар улс төрийн намуудын дүрэм, мөрийн хөтөлбөр төдийгүй намаас хууль тогтоох байгууллагад нэр дэвшигчдийг тодруулах зэрэг асуудлуудыг намын их хурал ба төлөөллийн байгууллагаар шийдвэрлэхээр босго тогтоосон учир намуудыг зөвхөн дүрмийн хүрээнд шинжилж үнэлгээ өгөх нь учир дутагдалтай юм. Иймд Израйлын Ардчилал Институтын боловсруулсан индексийн үнэлгээ нь намуудыг албан ёсны дүрмийн хүрээнд авч үзэхээс гадна бодит практик, туршлагыг нь тусгаж үнэлэх зорилготой юм. Энэхүү 2018 оноос эхлэн боловсруулж буй улс төрийн намын дотоод ардчиллын индекс нь тус судалгааны арга зүйд үндэслэсэн ба тухайн орны онцлогт тохируулсан зарим асуултыг монголын нөхцөлд тусган нарийвчилсан болно.

## ОРОЛЦОО

Улс төрийн оролцоо нь шийдвэр гаргах үйл явцад шууд ба шууд бусаар нөлөөлөхүйц олон төрлийн үйл ажиллагааг хамрах өргөн хүрээний ойлголт юм. Шийдвэр гаргагчдыг сонгох нь үүний нэг төрөл бөгөөд төрийн төдийгүй намын түвшний ардчиллын үндсэн зарчим юм (Рахат, Шапира 2016). Энэ утгаараа намын дарга ба намаас хууль тогтоох байгууллагад нэр дэвшигчид зэрэг намыг төлөөлөхүйц голлох үүрэгтэй шийдвэр гаргагчдыг хэрхэн сонгож байгааг энэ хэсэгт шинжилсэн.

Улс төрийн намын дотоод ардчиллыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн оролцоог зөвхөн албан дүрмийн хүрээнд баталгаажуулахаас гадна бодлого боловсруулах үйл явцад идэвхтэй оролцоог хангах нь чухал юм. Иймээс бодлогын баримт бичгүүдэд хэлбэр төдий бус бодитой оролцоог шинжлэхийн тулд боловсруулах ба батлах үйл явцыг салган авч үзлээ. Үүний дагуу намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон намаас өрнүүлсэн бодлогын мэтгэлцээнүүдэд намын гишүүд, дэмжигчдийг хүртээмжтэй оролцуулж байгаа эсэхийг шинжиллээ.

## ӨРСӨЛДӨӨН

Өрсөлдөөн нь оролцооны адил ардчиллын үндсэн, суурь нөхцөл. Гол зарчим нь сонгогчид саналаа өгөх хэд хэдэн сонголттой байхыг шаарддаг (Рахат, Шапира 2016). Энэхүү хэмжигдэхүүнээр намын их хурлаас сонгон байгуулсан төлөөллийн төв байгууллага, удирдах зөвлөл зэрэг намын дотоод бүтцийн байгууллагууд болон намын шийдвэр гаргах албан тушаалуудын сонгууль хийсэн эсэхийг шинжилсэн. Түүнчлэн эдгээр дотоод бүтцийн байгууллагуудын бүрэлдэхүүнийг өөрчлөх, намаас хууль тогтоох дээд байгууллагад нэр дэвшигчдийг сонгоход гишүүдийн оролцоо ямар түвшинд байгааг тодрууллаа.

## ТӨЛӨӨЛӨЛ

Энэхүү хэмжигдэхүүнээр намын дотоод бүтцийн байгууллагуудад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хэрхэн хамруулж буйг шинжлэв. Намын голлох шийдвэр гаргах албан тушаалуудад тэр дундаа хууль тогтоох дээд байгууллагад нэр дэвшигчдэд эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээнд үнэлэлт өглөө. Тухайлбал, сонгуульд нэр дэвшигчдэд эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээг зөвхөн сонгуулийн хуулийн шаардлагад нийцүүлэх бус сайн дурын хувь хэмжээг тогтоодог эсэхийг шинжиллээ.


## САНХҮҮЖИЛТ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Энэхүү хэсэгт улс төрийн намын ил тод байдал, тэр дундаа санхүүжилтийн ил тод байдлыг шинжилсэн. Улс төрийн намууд олон нийтийн байгууллага учраас гишүүддээ болон олон нийтэд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа гаргаж тайлагнах үүрэгтэй. Олон нийтэд тайлагнахаас гадна намын ерөнхий түвшинд болон нэгжийн түвшинд гишүүддээ тайлагнах зэргээр ялгаатай байгааг судалаллаа. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтуудад намынхаа мэдээллийг хэр зэрэг ил тод харуулж байгааг мониторинг байдлаар шалган намын дүрэм, намын мөрийн хөтөлбөр, намын дүрэм, журмууд, намын гишүүдийн мэдээлэл зэрэг нийт 9 шалгуурын хүрээнд дүгнэсэн.


# 1 УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2019 оны судалгааны үр дүн өмнөх жилээс харьцангуй өндөр байгаа нь намууд УИХ-ын 42-р тойргийн нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд бэлтгэх, нэр дэвшигчдээ тодруулах зорилгоор намын бүхий л түвшинд гишүүдийн оролцоо идэвхэжсэнтэй холбоотой гэж ойлгож болно. Мөн 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жил буюу улс төрийн намын гишүүдийн идэвхэждэг үе эхэлсэн нь дотоод ардчиллын индекс т нөлөөлсөн гэж судлаачдын зүгээс үзэж байна.


Зураг 1: Улс төрийн намын дотоод ардчиллын индекс



Зураг 2: Улс төрийн намын дотоод ардчиллын индекс, хэмжигдэхүүн тус бүрээр




Зураг 3: 2018 ба 2019 оны Улс төрийн намын дотоод ардчиллын индексийн харьцуулалт





## 1.1 УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО


Зураг 4: Улс төрийн намын гишүүдийн оролцоо



Энэхүү хэмжигдэхүүнээр намын дарга ба УИХ-д нэр дэвшигчид зэрэг намын шийдвэр гаргах гол албан тушаалтнуудыг сонгоход төдийгүй намын мөрийн хөтөлбөрийг боловсруулах, батлах үйл явцад гишүүд, дэмжигчдээ хэрхэн оролцуулж байгааг шинжилсэн. Энэ хүрээнд АН хамгийн өндөр оноо авсан нь намын даргаа сонгохдоо бүх гишүүдийг хамарсан сунгаа хийсэнтэй холбон тайлбарлаж болно. Мөн ХҮН намын бодлогыг тодорхойлоход анхаарч, түүнийхээ хүрээнд ажиллаж байгаа нь ажиглагдсан. Харин намуудын мөрийн хөтөлбөрөө боловсруулах, батлах үйл явц нь жижиг бүлэг буюу цөөн тооны гишүүдийн хүрээнд хязгаарлагдаж байна. Мөн нам дотор бодлогын мэтгэлцээн өрнөж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Намын дотоод асуудлыг хэлэлцдэг хэлбэрүүд түгээмэл боловч бодлогын асуудлууд дээр мэтгэлцээн өрнөж, намын бодлогыг томъёолох явцад гишүүд дэмжигчдийг оролцуулах явдал сул байгаа нь бүх намуудад нийтлэг ажиглагдаж байна. 2019 онд судалгаанд оролцсон нийт намуудын тус хэмжигдэхүүний дундаж оноо нийт 25 онооноос 12.87 байгаа нь өмнөх жилийн дундажтай (10.25) ойролцоо байна. Энэ нь авах ёстой онооны 51.48%-ийг авсныг илтгэнэ.

## 1.2 УЛС ТӨРИЙН НАМ ДОТОРХ ӨРСӨЛДӨӨН

Зураг 5: Улс төрийн нам доторх өрсөлдөөн



2019 онд судалгаанд оролцсон нийт намуудын дундаж оноо 13.5 байгаа нь өмнөх жилийн 16.28 онооноос харьцангуй буурсан үзүүлэлт юм. Энэ нь авах ёстой онооны 56.25%-ийг авсныг илтгэнэ. Үүнд парламентад суудалтай намуудын оноо голлон нөлөөлсөн байна. УИХ-д тогтмол суудалтай байсаар ирсэн АН, МАН зэрэг зонхилох намуудын шийдвэр гаргах албан тушаалуудын төлөөх өрсөлдөөн харьцангуй идэвхтэй олон нэр дэвшигчтэй байна. Харин цөөн гишүүд бүхий УИХ-д төлөөлөлгүй намуудын хувьд шийдвэр гаргах албан тушаалтнууд дахин сонгогдох тохиолдол түгээмэл, цөөн өрсөлдөгч, нэр дэвшигчтэй байна.

2019 онд парламентад суудал бүхий зонхилох хоёр намын дотоод ардчилалд сөрөг нөлөөтэй зарим тохиолдлууд гарсан юм. УИХ-д намын бүлэгтэй АН, МАН нь хууль тогтоох байгууллага дахь намын төлөөлөл бүхий гишүүдээ намын нэгдмэл байр сууринаас зөрсөн шалтгаанаар гишүүнчлэлээс нь түдгэлзүүлсэн. Тухайлбал, 2018 оны 12 дугаар сард Нийслэлийн засаг дарга үүрэгт ажлаа хүлээлгэн өгснөөр ээлжит албан тушаалтныг тодруулахаар болсон. Улмаар МАН-ын удирдах зөвлөл ба НИТХ-ын олонхийн санал авсан 2 нэр дэвшигч МАН-аас өрсөлдсөн ч удирдах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй шалтгаанаар нэг нэр дэвшигчийг намын гишүүнчлэлээс нь түдгэлзүүлсэн. Намын хяналтын хороо нэр дэвшигчийг намын эрх ашиг, Удирдах зөвлөл, намын бүх шатны байгууллагын шийдвэрийг зөрчсөн гэж үзэн доорх шийдвэрийг гаргажээ.

*МАН-ын Хяналтын ерөнхий хорооны дарга Д.Батбаяр:*


“МАН-ын дүрмийн 4.2.1, 4.2.5, 4.2.8, 4.2.9, 4.2.10, 4.2.12 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж С.Мөнхчулууныг МАН-ын гишүүнээс гарсанд тооцсон шийдвэрийг гаргалаа.

***Монгол Ардын Намын дүрэм - 6 дугаар зүйл. Монгол Ардын Намын гишүүнээс гарах***

- 6.5 Монгол Ардын Намын гишүүнийг дараах тохиолдолд намаас гарсанд тооцно:***
- 6.5.1 Намаас УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчтэй зэрэгцэн бие даан нэр дэвшсэн нам болон намын нэр дэвшигчийн эсрэг сурталчилгаа хийсэн,***
  - 6.5.2 Намаас сонгогдсон буюу томилогдон төрийн өндөр албан тушаал эрхэлж байх хугацаандаа авлигын гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон,***
  - 6.5.3 Намын бүх шатны сонгуульд нэр дэвшигч нь санал худалдаж авах үйлдэл гаргасан,***
  - 6.5.4 Намын албан ёсны шийдвэр буюу олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлаар энэ дүрмийн 1.5.4-т заасан зарчмыг зөрчсөн***

### 1.3 УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨӨЛӨЛ

Зураг 6: Улс төрийн намын төлөөлөл



Улс төрийн намын тухай хуулиар аливаа нэр дэвшигчийг тодруулах асуудлыг намын их хурал ба сонгож байгуулсан төлөөллийн байгууллага нь шийдвэрлэхээр зохицуулсан. Гэвч нэр дэвшигчдийг тодруулах үйл явц нь намын нийт гишүүд, дэмжигчдийн санал, шийдвэрийг хэдий хэмжээнд тусгасан, ямар үйл явцаар шийдвэр батлагдсан эсэх нь харилцан адилгүй байдаг.


Энэхүү хэмжигдэхүүнээр авсан намуудын дундаж 8,3 оноо буюу авах ёстой онооны 51.87%-ийг авсныг илтгэнэ. Бусад хэмжигдэхүүнүүдтэй харьцуулахад намууд нэр дэвшигчдийг сонгоход эмэгтэйчүүдийн хувь хэмжээг сайн дураар нэмж нэвтрүүлээгүй, намын дотоод бүтцийн байгууллагуудын сонгуулийг хийгээгүй, зарим тохиолдолд уг сонгуулийг хийдэггүй зэрэг асуудлууд байв.

Улс төрийн нам доторх дотоод хяналтыг УТНХ-иар зохицуулсан байдаг. Судалгаанд оролцсон улс төрийн намуудад нам доторх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бүтэц тухайлбал, ёс зүйн хороо, сахилгын хороо, хяналтын хороо гэх мэт хяналтын бүтэц МАН, АН гэсэн орон нутаг бүрт бие даасан салбар нэгжүүдтэй намын анхан, дунд, дээд шатанд байдаг. Харин бусад намуудын хувьд аль нэг түвшинд намын дүрмийг баримталж хариуцлагатайгаар ажилладаг байна.

Улс төрийн намын тухай болон Сонгуулийн тухай хуулиудаар хүйсийн тэгш байдлыг хангах зарчмын зохицуулалт байдаг. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 126.2 дахь хэсэгт сонгуульд өрсөлдөх улс төрийн нам ба эвслийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн эмэгтэй хүйсийн төлөөлөл 20 хувь байхаар заасан. Харин уг индекст улс төрийн намууд сайн дурын квот ашиглаж намын дүрэмдээ эмэгтэй нэр дэвшигчид 30 хүртэлх хувь байхаар тусгасан байгаа. Энд 30 “хүртэлх” хувь гэж орж ирсэн нь квотод хүрэхгүй байсан ч болно гэсэн утгыг агуулж байна. Судалгаанд оролцсон парламентад суудалгүй улс төрийн намуудын хувьд эмэгтэй нэр дэвшигчдийг уг квотод заасан хувиар орон нутгийн болон УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх гэтэл төдий тооны эмэгтэйчүүд байдаггүй гэсэн хариултыг судалгаанд оролцогчид дурдаж байв. Энд эмэгтэйчүүдэд улс төрийн эрхээ эдлэхэд сонгуульд зарцуулах санхүүжилт, нийгмийн болон амьдралын нөөц бололцоо ховор, ихээхэн дэмжлэг хэрэгтэй байгааг харуулж байгаа юм.

## 1.4 УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ БА ИЛ ТОД БАЙДАЛ

Зураг 7: Улс төрийн намын санхүүжилт ба ил тод байдал



2019 онд судалгаанд оролцсон нийт намуудын тус хэмжигдэхүүний дундаж оноо нийт 35 онооноос 12.87 байгаа нь авах ёстой онооны 56.28 хувийг авсныг илтгэнэ.

Монгол Улсын хувьд улс төрийн намын гишүүн, нэр дэвшигчид гишүүний татварын хэмжээ, татвар төлөх хугацаа, татвар хураах зэрэг асуудлыг намуудын дотоод дүрэм, журмаар зохицуулж байна. 2005 оны Улс төрийн намын хуулийн 18 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт гишүүн намын дүрмээр тогтоосон хэмжээгээр татвар төлөхөөр заасан байна. Гэхдээ манай намуудын хувьд гишүүдийн татвараас авч буй мөнгө намын нийт санхүүжилтэд өндөр хувь эзэлдэггүй нь судалгааны явцад батлагдлаа. Гишүүнээс авч буй татварын тайлан,

зарцуулалтыг намын тухайн шатны байгууллагуудад танилцуулдаг. Зарим намуудын хувьд өөрийн харьяаны анхан шатны нэгжээс бусад санхүүгийн тайланг авч үзэх боломжгүй байгаа нь ил тод байдлыг зөрчсөн үйлдэл юм. Намын үйл ажиллагааны болон санхүүгийн тайландаа аудит хийлгэн баталгаажуулж олон нийтэд нээлттэй байдлаар танилцуулдаг сайн жишиг бүхий парламентад суудалгүй намууд байна.

Намын гишүүний татварыг төлөх үүрэгтэй байх нь улс төрийн намын гишүүд намын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох, төлсөн татварын зарцуулалтад хяналт тавих боломжийг нэмэгдүүлж, удирдах зөвлөл бие даан шийдвэр гаргадаг тогтолцоог багасгаж,

намын дотоод ардчиллыг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

Ингэхдээ улс төрийн намын гишүүд өөрийн төлж буй татварын зориулалтыг зааж өгөх (иргэдийн улс төрийн боловсролд, сонгогчдын сонгуулийн боловсролд, иргэдээс авах судалгаанд, намын бодлого мөрийн хөтөлбөрийг боловсруулахад гэх мэт), эргээд зарцуулалтын тайланг үздэг, хяналт шалгалт хийдэг болох шаардлагатай.

Улс төрийн намын гишүүд хоорондын мэдээлэл авах эх сурвалжийн хувьд фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн сүлжээний хэрэгслүүдээс гадна уламжлалт харилцаа холбооны гар утсаар, имэйлээр мэдээлэл хүргэх зэрэг сувгууд давамгайлж байна. Улс төрийн нам нь үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод явуулах зарчмыг хуулиар хүлээсэн олон нийтийн байгууллага билээ. Гэвч улс төрийн намуудын дотоод нөөц бололцоо харилцан адилгүй, дийлэнх улс төрийн намууд албан ёсны цахим хуудасгүйн улмаас олон нийт намуудын албан

ёсны дүрэм, үйл ажиллагаатай танилцах боломж хязгаарлагдмал байна. 2019 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам, Монголын Ногоон Нам, Хөдөлмөрийн Үндэсний Нам зэрэг нийт 5 нам албан ёсны вебсайт ашиглаж үйл ажиллагааны талаарх мэдээллээ олон нийтэд түгээж байна.

Улс төрийн намын тухай хуулийн дагуу УДШ улс төрийн намуудыг улсын бүртгэлд бүртгэснээр үйл ажиллагаагаа явуулах төдийгүй намын дүрэмд оруулсан өөрчлөлт тутмыг хянан холбогдох хуульд нийцсэн эсэх шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй. Улмаар судалгааны баг улс төрийн намуудын дүрмийг хуулбараар авах албан хүсэлтээ УДШ-д 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр хүргүүлсэн ч Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасныг үндэслэн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг тухайн этгээд өөрөө бичгээр зөвшөөрсөн байх шаардлагатай гэж үзэн татгалзсан юм.

### ***Улсын бүртгэлийн ерөнхий хууль***

#### ***12 дугаар зүйл. Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл өгөх***

12.5 Энэ хуулийн 12.3-т зааснаас бусад мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй олгоно.

Энэ нь УДШ бүртгэлтэй намуудын мэдээлэл хуучирсан, зарим тохиолдолд худлаа буюу мэдээллийг шинэчлэдэггүйтэй холбоотой. Намуудын холбогдох албан тушаалтнуудын утас холбогддоггүй, ашиглалтад байхгүй зэргээр судалгааны багийнхан холбоо барихад хүндрэл үүсч байсан. Намуудын мэдээлэл албан ёсны эх үүсвэрээс мэдээллийг авахад хүндрэлтэй байгаа тул иргэдэд ч нээлттэй бус байгааг харуулж байна.

## 2. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны энэ хэсэгт бид улс төрийн намуудад зөвлөмж болох үүднээс гадны орнуудын улс төрийн намуудын сайн туршлагуудаас хуваалцаж байна. Дотоод ардчиллын индексийн дөрвөн гол хүрээ болох оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн хүрээнд бид зарим нэг туршлагыг хуваалцаж байна. Гол зорилго намын дотоод ардчиллаа сайжруулахад санаа өгөх зорилготой юм. Тиймээс шууд Монголын улс төрийн намуудад шууд тохирно гэж үзээгүй гэдгийг анхаарах шаардлагатай. Ер нь улс төрийн намын дотоод ардчиллыг зөвхөн намын тухай хуулиар хязгаарлахгүй, үндсэн хуулиар ч байх ёстой шаардлага гэж хуульчилсан тохиолдлууд цөөнгүй бий. Энэ нь улс төрийн нам, цаашлаад ардчиллын хөгжилд зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулж байгаа юм.

### **Испани улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйл**

*"Улс төрийн намууд бол улс төрийн олон ургальч үзлийн илэрхийлэл бөгөөд ард түмний хүсэл зоригийг илэрхийлэхэд хувь нэмрээ оруулж, улс төрийн оролцооны үндсэн хэрэгсэл болдог. Нам үүсгэн байгуулах болон үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль болон бусад хуулийг сахиж, дотоод бүтэц, үйл ажиллагаа нь ардчилсан байх ёстой."*

### **ОРОЛЦОО**

- Шинэ Зеландын Хөдөлмөрийн намын гишүүд намын бодлого, мөрийн хөтөлбөрт шууд хувь нэмэр оруулж, намын тунхаглалд тавьсан амлалтыг хэрэгжүүлэхэд нь туслах боломжтой. Мөн орон нутгийн намын бүх гишүүдийн оролцож болох бодлогын форумаас гарсан саналыг Бодлогын хороодод хүргэж болно. Бодлогын хороод ирсэн саналуудыг чуулганаар хэлэлцэгдэж, батлагдвал намын бодлого болох юм.
- АНУ-ын Ардчилсан болон Бүгд найрамдах намууд орон нутгийн, мужийн, холбооны түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг. Намуудын дотоод ардчилал нь нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлэх үйл явцад тод илэрдэг. Намаас нэр дэвшүүлэх ажлыг анхан шатны сонгуулиар тодорхойлдог.
- Намууд нээлттэй дотоод сонгуулиар нэр дэвшигчээ гишүүдийн саналд тулгуурлаж сонгодог.
- Исланд улсад нөлөө бүхий 4 нам парламентад тогтмол сонгогдог. Эдгээр дөрвөн нам бүгд өөрсдийн үндэсний чуулганаа хоёр жил тутам зохион байгуулдаг. Намын хурлаар намаас баримталж буй бодлогыг хэлэлцэж баталдаг. Хурлын төлөөлөгчдийг орон нутгийн нэгж бүрийн намын гишүүдийн тоотой шууд пропорционалиар бүрдүүлдэг. Намын хурлын төлөөлөгчийг сонгохдоо уламжлалт дотоод сонгуулийг ашигладаг бөгөөд гишүүд оролцох эрхтэй.
- Герман намаас нэр дэвшүүлэх үйл явцыг эрх зүйн хүрээнд хуулиар нарийн зохицуулсан байдаг. Германд намаас нэр дэвшүүлэх үйл явц мужийн



түвшинд хэрэгждэг. Шийдвэр нь анхан шатны сонгууль, эсвэл дунд шатны байгууллагын төлөөлөгчдийн хурлаас гардаг. Шийдвэр гаргах үйл явцыг нарийн хуульчилсан байдаг бөгөөд үүнийгээ сонгуулийн хуульд тодорхой заасан байна. Намын лидерүүд сонгуулийн дүүрэг, муж тус бүрээр нэр дэвших жагсаалтыг бэлтгэдэг бөгөөд дараа нь намын гишүүдэд жагсаалтыг илгээж баталгаажуулдаг. Энэ тохиолдолд намын лидерүүд нөлөөлөх эрх байдаггүй.

### ӨРСӨЛДӨӨН

- Ардчилал хөгжсөн орнуудын туршлагаас харахад намын фракцыг чөлөөт хэлбэрээр хөгжүүлсэн байдаг нь намын гишүүний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөтэй нь холбоотой. Тухайлбал, судлаач А.Лийпхарт “Ардчиллын хэв загвар: гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл” бүтээлдээ Колумбын Либерал болон Консерватив нам, Энэтхэгийн Конгресс нам, Италийн Христосын Ардчилсан нам, Японы Либерал Ардчилсан нам, АНУ-ын намыг дотоод фракцууд чөлөөтэй байдаг намууд гэж дурдаж болно. Гэхдээ эдгээр намуудыг дотроо зөрчилтэй, эв нэгдэлгүйн жишээ болно гэвэл учир дутагдалтай гэж үзсэн. Учир нь улс төрийн нам бол “нэгдмэл тоглогч” биш юм гэж үзжээ.

- Фракцыг хязгаарласан намуудын туршлага нь ихэвчлэн коммунист үзэл сурталтай, лидерийн эрх мэдэл хүчтэй байдаг улс төрийн намд ажиглагддаг. Иймээс улс төрийн ардчиллыг бэхжүүлэхэд улс төрийн намууд чөлөөт клуб, дугуйланг (фракц) шийдвэр гаргах түвшинд хэрхэн оролцуулж байгаагаас нь дүгнэж болох юм. Энэ нь мөн шийдвэр гаргах үйл явцад өөрсдийн санаа, бодлыг нэгтгэх ач холбогдолтой ажээ.

### ТӨЛӨӨЛӨЛ

- Бельги улс 1994 оны 5 сарын 24 ны өдөр баталсан Сонгуулийн хуулиар намын ямарч сонгуульд нэр дэвших хүмүүсийн жагсаалтад 2/3-оос илүүгүйгээр хүйсийн харьцааг барих. Доод тал нь төлөөлөгчдөд тавигдах шаардлага нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст ижил байх. Энэ нь бүх шатны сонгуульд байгууллагуудад ижил үйлчлэхийг зааж байсан [109,21].
- Францад 1999 онд намын хууль болон үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалтад эмэгтэйчүүдийн төлөөллийг 50 хувь болгож өсгөсөн. Улмаар төрийн албанд ажиллагсад эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь 27-47 хувь болж өссөн. Мөн 2002 онд Үндэсний ассамблейд сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо 10,9 өөс 12,3 болж 1,4 хувиар өссөн байна.

Улс төрийн намын дотоод төлөөллийн байгууллагад нэр дэвшигчийн болон суудал хадгалах квотуудыг хэрэглэх нь үр ашигтай. Учир нь үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн өмнө нам дотоод байгууллагуудаараа дамжуулан эмэгтэйчүүдэд улс төрийн боловсрол олгох, улс төрд өөрийгөө таниулах, туршлагажих боломжийг олгох шаардлагатай. Иймээс намууд сайн дурын квотыг дотоод дүрэм, журмаар зохицуулдаг.

**Хүснэгт 2: Эмэгтэйчүүдийн квотын төрөл**

Квотын төрөл	Улс	Тайлбар
Хуулиар нэр дэвшигчийг дэмжих квот (Legal quota)	Франц	1999 онд Үндсэн үзэл санааг шинэчлэн найруулснаар засгийн газар болон улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн. Мөн сонгуулийн хуульд 2000 онд нэмэлт өөрчлөлт оруулж бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн 50% нь эмэгтэй нэр дэвшигч байхаар хуульчилсан.
	Аргентин	Нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь эмэгтэй байх
	Өмнөд Африк	Нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь эмэгтэй байх
Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квот (Reserved seats quota)	Танзани	Парламентын суудлын 20% нь эмэгтэй гишүүнд
	Энэтхэг	Орон нутгийн хууль тогтоох дээд байгууллагын суудлын 33% эмэгтэй гишүүд байх
Улс төрийн нам доторх квот (Voluntary quota)	Швед	Социал Демократ Нам сонгуулийн нэрийн жагсаалтад эрэгтэй эмэгтэй хоёр нэр дэвшигчдийг дэвшүүлдэг. /zipper system/
	Норвеги	Хөдөлмөрийн намын нэр дэвшигчийн жагсаалтад 40%-оос доошгүй хувь нь эмэгтэй нэр дэвшигч байдаг.

**НАМЫН САНХҮҮЖИЛТ БА ИЛ ТОД БАЙДАЛ**

- Намын дотоод ардчилал төдийгүй дэлхийн улс орнуудын намын тухай хуулийн эх сурвалж болсон Германы улс төрийн намын тухай хуульд намын үндсэн дүрэм, журам, мөрийн хөтөлбөр, намын төлөөллийн төв байгууллага болон орон нутгийн нэгжийн шийдвэр гаргах албан тушаалтнуудын нэр, чиг үүргийн талаарх мэдээлэл, түүнийг хуулбараар авах эрхийг нийтэд үнэ төлбөргүй олгохоор баталгаажуулсан байдаг.

**ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хууль**

**2 дугаар зүйл. Бүртгэлийн шаардлага**

2.3.6 Улс төрийн намууд нь дараах бичиг баримтыг Federal Returning Officer-т хүргүүлнэ:

- намын дүрэм, журам
- намын мөрийн хөтөлбөр
- намын төв болон орон нутгийн нэгжийн удирдах албан тушаалтнуудын нэр, чиг үүрэг.

Эдгээр бичиг баримтыг нийтэд үнэ төлбөргүй олгоно.

- Барууны ардчилсан улс оронд ардчилал амжилттай бэхжихэд нөлөөлсөн нэг хүчин зүйл, бодлогын асуудал бол улс төрийн намын санхүүжилтийг сайтар зохицуулж өгсөн явдал юм. Энэ нь хожим улс төрийн намуудыг дотоод ардчилал бүхий институт, улс төрчдийг хариуцлагатай болж төлөвшихөд шууд нөлөөлсөн гэж үздэг. Тухайлбал, АНУ, Канад, ХБНГУ зэргийг дурдаж болно.

### 3. ДҮГНЭЛТ

Улс төрийн намуудын үйл ажиллагаа, дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, намын санхүүжилт ба ил тод байдал гэсэн дөрвөн гол үзүүлэлт тус бүрт судалгааны арга зүйн дагуу тодорхой оноо өгөн дүгнэсэн болно.

Дээрх ангиллын хүрээнд судалгаанд хамрагдсан улс төрийн 8 намын гишүүдээс авсан асуулгаар нийт 100 онооноос: 1) МНН - 66 оноо 2) МАХН - 66 оноо 3) АН - 65 оноо 4) ХҮН - 63 оноо 5) МАН - 55 оноо 6) ЭОН - 47 оноо 7) ҮЗН - 42 оноо 8) ИЗНН - 32 оноог тус бүр авлаа.

Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгаанд хамрагдсан намуудыг авсан оноогоор дүгнэж болох ч оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, намын санхүүжилт ба ил тод байдал гэсэн 4 үзүүлэлт тус бүр дээр нам бүрийн авсан оноо харилцан адилгүй, өөрчлөлттэй гарсныг анхаарах хэрэгтэй. Улс төрийн намын дотоод ардчиллын индексийн 2018 оны судалгааны дүнд судалгаанд оролцсон 6 нам “хагас ардчилсан” ангилалд багтаж байсан бол энэ удаагийн судалгааны дүнгээр Монголын Ногоон нам, Монгол Ардын Хувьсгалт нам, Ардчилсан нам, Хөдөлмөрийн Үндэсний намууд “ардчилалтай” ангилалд дэвшин орж ирлээ. Мөн энэ жилийн судалгаанд Монголын Ногоон нам, Үнэн ба Зав намууд нэмэгдэн оролцлоо.

2019 оны 4 дүгээр сараас 6 дугаар сард хийсэн энэ удаагийн судалгаа нь УИХ-ын 42-р тойргийн нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд бэлтгэх, нэр дэвшигчдээ

тодруулах зорилгоор намын бүхий л түвшинд гишүүдийн оролцоо идэвхжсэн, 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жил буюу улс төрийн намын гишүүдийн идэвхтэй болдог үе эхэлсэнтэй холбоотойгоор намуудын улс төрийн идэвхтэй үе таарч байгаагаараа онцлог байлаа.

Судалгааны оролцоо, төлөөлөл хэсгийн дүнд МАН, АН судалгаанд оролцсон улс төрийн намуудаас бага оноо авсан нь тухайн намаас Ерөнхийлөгчийн, УИХ-ын, орон нутгийн сонгуульд нэр дэвших эрхээ авахын тулд намдаа төлж буй “дэнчин” нөлөөлж үнэлгээ аваагүй. Ардчиллын суурь зарчим болох сонгогдох эрхээ тухайн намын гишүүд нээлттэй эдэлж чадахгүй байгаа нь судалгааны тухайн хэмжигдэхүүний хэсэгт оноо авах үндэслэлгүй байлаа. Сонгогдох эрхийг эдлэхийн тулд “мөнгө-дэнчин” өгч намаас нэр дэвшиж байгаа нь мөнгөтэй, бизнес эрхэлдэг нэр дэвшигчдийн ашиг сонирхол улс төрд гарах, эргээд сонгогдохын тулд зарцуулсан мөнгийг олж авахын тулд ажиллах зэрэг сул талууд гардаг тул нийт сонгогчдын сонгох эрх ноцтой зөрчигддөг сул тал байдаг.

МАН, АН орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжүүдийн тоогоор тэргүүлж, МАХН орон нутагт салбар бүтэц, анхан шатны нэгжийн тоогоор гуравдугаарт орж байна. Дээрх гурван намаас бусад намууд бүтэц зохион байгуулалтын хувьд орон нутагт

байх намын гишүүдийг бүрэн дэмжин ажилладаг хэдий ч зарим намын гишүүд өөрийн намын нэрээр ажиллах хүндрэлтэй, орон нутагт намын талцал их, тухайн үед эрх баригч намаас өөр намын гишүүдийг ажил хийхэд саад учруулдаг, гадуурхдаг зэрэг хүндрэл гардаг тул орон нутагтаа амьдрахдаа намын гишүүн биш мэтээр ажиллах, амьдрах сонирхолтой байдаг болсон гэж судалгаанд оролцогч намуудын төлөөлөл ярьж байлаа.

Улс төрийн намын тухай болон Сонгуулийн тухай хуулиудад хүйсийн тэгш байдлыг хангах зарчмын зохицуулалт байдаг. Үүнийг улс төрийн намууд сайн дурын квот ашиглаж намын дүрэмдээ эмэгтэй нэр дэвшигчид 30 хүртэлх хувь байхаар тусгасан байгаа нь квотод хүрэхгүй байсан ч болно гэсэн утгыг агуулж байна. Судалгаанд оролцсон парламентад суудалгүй улс төрийн намуудын хувьд эмэгтэй нэр дэвшигчдийг уг квотод заасан хувиар орон нутгийн болон УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх гэтэл төдий тооны эмэгтэйчүүд байдаггүй, нэр дэвшүүлж чадахгүй байна гэсэн хариултыг судалгаанд оролцогчид дурдаж байв. Энд эмэгтэйчүүдэд улс төрийн эрхээ эдлэхэд сонгуульд зарцуулах санхүүжилт, нийгмийн болон амьдралын нөөц бололцоо ховор, ихээхэн дэмжлэг хэрэгтэй байгааг харуулж байгаа юм.

Судалгааны явцад намуудын дүрмийг судлахын тулд УДШ мэдээллийг авахаар хандсан боловч Улсын бүртгэлийн тухай хуулиар мэдээллийг судалгааны

багт өгөхийг татгалзсан. Судалгаа хийх зорилгоор мэдээлэл хайхад УДШүүхэд бүртгэлтэй намуудын мэдээлэл хуучирсан, зарим тохиолдолд худлаа буюу мэдээллийг шинэчлэдэггүй нь дахин ажиглагдлаа. Мөн намуудын холбогдох албан тушаалтнуудын утас холбогддоггүй, ашиглалтад байхгүй зэргээр судалгааны багийнхан холбоо барихад хүндрэл үүсч байсан. Намуудын мэдээлэл албан ёсны эх үүсвэрээс мэдээллийг авахад хүндрэлтэй байгаа тул иргэдэд ч нээлттэй бус байгааг харуулж байна.

Улс төрийн намын дотоод ардчиллын индексийн судалгааг хийснээрээ уг асуудалд хандуулах намуудын анхаарал нэмэгдэж, гишүүд болон сонгогчдын улс төрийн боловсролыг нэмэгдүүлэх үүргээ биелүүлэхэд анхаарч ажиллах, судалгаанд суурилсан бодлого, хөтөлбөр гаргах зэрэг үр дүнгүүд гарах ач холбогдолтой. Манайд улс төрийн дээрх судалгаа болон бусад орнуудын шилдэг туршлагаудтай харьцуулахад дараах хэд хэдэн зүйл анхаарах шаардлагатай гэж зөвлөж байна.

Улс төрийн намууд шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь эмэгтэйчүүдэд улс төрийн боловсрол олгох чухал суваг мөн. Ялангуяа намын дотор болон үндэсний хэмжээний төлөөллийн байгууллагад нэр дэвшигчийг тодруулахдаа квотыг ашиглах нь оновчтой бодлого юм. НҮБ болон ардчилал хөгжсөн бусад улсууд эмэгтэйчүүдийн оролцоог

нэмэгдүүлэхийн тулд хууль, эрх зүйн заалтуудад дараах гурван хэлбэрээр өөрчлөлт оруулахыг зөвлөж байна. Үүнд, эрх зүйн квот, суудал хадгалах квот, сайн дурын квот зэрэг болно.

Намын санхүүжилтийн эх үүсвэр улс орнуудад намын гишүүний татвар, намын үйл ажиллагаа, эд хөрөнгийг түрээслүүлснээс олсон орлого, намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү, иргэн болон хуулийн этгээд, шашны байгууллага, олонулсын байгууллагуудаас өгсөн хандив, төрийн санхүүжилт зэрэг олон хувилбараар санхүүжилт бүрддэг. Санхүүжилтийн олон хувилбарыг зөвшөөрдөг улсууд байдаг ч ардчиллын суурь зарчмуудыг хэрэгжүүлэх, бэхжүүлэхэд гол нөлөө үзүүлж дэмждэг улс төрийн санхүүжилтийн эх сурвалжийг бодлогоор дэмжин хуулийн зохицуулалт хийж байгаа улсууд ч байна.

Улс төрийн намын санхүүжилтийг хянах, зохицуулах нь засаглалд ойр нөлөө бүхий намуудыг улс төрийн авлигад

өртөх, сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх ач холбогдолтой. Бодит байдалд улс төрийн намын сонгуульд зарцуулах мөнгө жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд зардлын санг бүрдүүлэхэд нөлөө бүхий бизнесийн салбарын төлөөлөгчдийг татаж байдаг. Мөн сонгуульд нэр дэвших улс төрчид сонгуулийн үед гаргасан зардлаа хэрхэн нөхөх тухай асуудал толгойны өвчин болж байдаг нь намын санхүүжилтийг хянах, зохицуулах зайлшгүй шаардлагатайг нотолж байна. Энэ нь шууд утгаараа улс төрчид болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой эрх зүйн зохицуулалт ардчиллыг дэмжих чухал бодлого болохыг илтгэж байна. Ийм бодлого байхгүй эсвэл сул байгаа нь магадгүй улс төрийн намуудыг дотоод ардчилалгүй байх, ардчиллыг дэмжих улс төрийн институт болж төлөвшиж чадахгүйд хүргэж байгааг үгүйсгэхгүй.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- ◆ *Гэрэлт-Од, Э. (2009) Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш)*
- ◆ *Лийпхарт, А. (2008) Ардчиллын хэв загвар: гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл /орч/*
- ◆ *Мөнхбат, С. (2009) Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшилтийн зарим асуудал*
- ◆ *Эрдэнэдалай, Б. (2015) Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал*
- ◆ *The Asia Foundation, (2017) Survey on Perceptions and Knowledge of Corruption*
- ◆ *Ballington, J. (2004) Strengthening Internal Political Party Democracy: Candidate Recruitment from a Gender Perspective*
- ◆ *Cross, W. & Katz, R. S. (2013) The Challenges of Intra-Party Democracy, Oxford, Oxford University Press.*
- ◆ *Diamond, L. & Gunther, R. (2001) Parties and Democracy, Prince University Press.*
- ◆ *Gauja, A. () Internal Party Democracy and Policy Formulation: Rationales, Trends, Relevance*
- ◆ *Norris, P. (2004) Building Political Parties: Reforming Legal Regulation and Internal Rules*
- ◆ *LeDuc, L. & Nieme, R. G. (1996) Comparing Democracies: Elections and Voting in Global Perspectives*
- ◆ *Rahat, G. & Shapira, A. (2016) An Intra-Party Democracy Index: Theory, Design & A Demonstration*
- ◆ *Transparency International (2007), Global Corruption Barometer*
- ◆ *Von dem Berge, B., Poguntke, T., Obert, P. & Tipej, D. (2013) Measuring Intra-Party Democracy*

# ХАВСРАЛТ

Хавсралт 1: Ардчилсан намын вебсайт, [www.demparty.mn](http://www.demparty.mn)

Утас: 1800-1206, 11-320355 | И-мэйл: info@demparty.mn

АРДЧИЛСАН НАМ

НҮҮР | АРДЧИЛСАН НАМ | МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ | САЛБАР | ХОЛБОГДОХ

С.Эрдэнэ: Их хурлын гишүүдтэй ёс зүйн хариуцлага тооцдог хууль зайлшгүй байх ёстой

Б.ГАН-ОЧИР: АРДЧИЛСАН НАМЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН ЯЛАГДЛЫН ХАМГИЙН ТОМ ОЛОЛТ НЬ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ардчилсан намын ҮБХ болон Ардчилсан Залуучуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ган-Очиртой Ардчилсан намын Үзэл бар...

Ардчилсан намын дарга С.Эрдэнэ ДРГерхард Ваалерсыг хүлээн авч уулзлаа

ШИНЭ

Б.Ариун-Эрдэнэ: Бид амин чухал боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн

1 хоногийн өмнө

Б.Ган-Очир: Ардчилсан намын 2016 оны сонгуулийн ялагдлын хамгийн том ололт нь Үзэл баримтлал

1 хоногийн өмнө

Г.Очирбат: Хангайн бүсийн чуулга уулзалтад таван аймаг, хоёр дүүргийн 800 орчим залуус оролцоно

ЗОРИЛГО | ҮЗЭЛ | ЖУРАМ | ДҮРЭМ

Хавсралт 2: Монгол ардын намын вебсайт, [www.nam.mn](http://www.nam.mn)

Social: Facebook • Twitter • Google+ • Instagram • Youtube

МОНГОЛ АРДЫН НАМ

МАН | Мэдээ | БИД ХАМТДАА аян | Цахим нам | Мэдлэг боловсрол | ТББ | Холбоо барих

Хайх...

ОНЦЛОХ МЭДЭЭ

Засгийн газрын хуралдаан 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдөр болж дарваж асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргалаа

Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлээ

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төрийн далбааны өдөрт зориулсан ёслолын арга хэмжээнд оролцов

Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой Монголын хуульчдын холбооноос ирүүлсэн саналуудыг хэлэлцэв

Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг

СҮҮЛД НЭМЭГДСЭН: ЗАСГИЙН ГАЗАР

Нэр бүхий хүмүүсийг Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагналаа


УИХ-ын дарга Г.Занданшатар "Гамшигт өртсөн Эрхүү мужийнханд туслах сайн санааны аян өрнөж байна" гэв

Их эзэн Чингис хааны музей байгуулна


Дахин болон Нөхөн сонгуулиудад МАН ялалт байгууллаа

Ерөнхий сайд У.Хуралсүх: Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртээ анхаарал, халамж тавьж ажиллах ёстой

**Хавсралт 3:** Монгол ардын хувьсгалт намын вебсайт, [www.maxh.mn](http://www.maxh.mn)



**Хавсралт 4:** Хөдөлмөрийн үндэсний намын вебсайт, [www.hunnam.mn](http://www.hunnam.mn)





*Хавсралт 5: Хөдөлмөрийн үндэсний намын санхүүгийн тайлан***2018 ОНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ**

Хөдөлмөрийн Үндэсний намын 2018 оны санхүүгийн тайланд Аклар Аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргалаа. Намын санхүүжилт, зардлын тойм дүнг үзүүлбэл:


ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ДҮН, төг	ТАЙЛБАР
<b>Мөнгөн орлого</b>	<b>37,880,800</b>	
Гишүүдийн татвар, хураамж	18,301,710	2018 оны намын гишүүдийн татвар болон УЗ-ийн гишүүдийн хураамжийн дүн
Хандив	18,449,090	2018 онд ХҮН намд нийт 78 иргэн 18,449.090 төгрөг хандивласан байна
Бусад	1,130,000	7 хандивлагчийн нэр, регистр зэрэг мэдээлэл дутуу байгааг тодруулахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна
<b>Мөнгөн зарлага</b>	<b>31,600,700</b>	
Нийгмийн даатгалын байгууллага	8,424,500	Өмнөх жилүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төлж барагдуулсан
Татварын байгууллагад төлсөн	4,956,000	Өмнөх жилүүдийн татварын өрийг төлж барагдуулсан
Хууль зүйн үйлчилгээний хөлс	2,500,000	Веритас Парнерс хуулийн фирмтэй "Монгол төрөө хулгайч бирдүүдээс цэвэрлэе!" аяны хүрээнд хамтран ажилласан гэрээт ажлын төлбөр
Ашиглалтын зардал	963,200	Гишүүд, дэмжигчдийн үүлзалтын байрны түрээсийн зардал
Үйлчилгээний зардал	1,146,000	Аудит, санхүүгийн тайлан гаргах, нотариатын үйлчилгээний зардал
Бичиг хэргийн зардал	414,600	Бичиг хэргийн зардал
Хэвлэл, мэдээллийн зардал	13,196,400	Хэвлэлийн хурал, хэвлэлийн мэдээний зардал
<b>Цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>6,280,100</b>	

Бидэнд итгэл үзүүлж, биднийг дэмжин хандив өгч, хамтран ажилласан нийт гишүүд, дэмжигчиддээ баярлалаа. Бид Та бүгдийн итгэлийг алдахгүй тууштай ажиллах болно.


**ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ**

2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

**Хавсралт 6:** Монголын ногоон намын вебсайт, [www.mongoliangreenparty.mn](http://www.mongoliangreenparty.mn)



**Хавсралт 7:**  
Монголын ногоон намын санхүүгийн тайлан,  
[www.mongoliangreen-party.mn/?p=1459](http://www.mongoliangreen-party.mn/?p=1459)







Union building, UNESCO Street 1st khoroo,  
Sukhbaatar district, Ulaanbaatar 14230, Mongolia  
E-mail: [origo@jargaldefacto.com](mailto:origo@jargaldefacto.com)  
Web: [www.defacto.mn](http://www.defacto.mn)